



МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/327

Эрдэнэбулган сум

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт,
архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр
авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 "а", Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 50 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамж, Засгийн газрын 2020 оны 106 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамжийн дагуу тус аймагт явагдсан "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтын улсын үзлэг" үр дүнтэй болсныг сайшаасугай.

2. Аймгийн Засаг даргын нэрэмжит "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үзлэг"-ийг орон нутагт 2021 онд зохион байгуулсугай.

3. Архив, албан хэрэг хөтлөлтийн салбарын хууль тогтоомж, эрх зүйн актыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, үзлэгийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж ажиллахыг сумдын Засаг дарга, агентлаг, төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

4. Байгууллагын архив, бичиг хэргийн ажилтныг мэргэшүүлэх, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг хууль, заавар журамд нийцүүлэн шаардлагын түвшинд хэрэгжүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

5. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулах, шинээр конторын барилга байгууламжийн зураг төсөл хийлгэхдээ архивын зориулалтын өрөөг төлөвлөх, архивын өрөөг зохих заавар,

стандартын дагуу тохижуулах, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

6. Улсын үзлэгт "А" үнэлгээтэй буюу "Маш сайн" дүгнэгдэж эхний 3 байрт шалгарсан байгууллагын удирдлага, архив, бичиг хэргийн ажилтныг шагнаж урамшуулах саналыг танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Цэрэннадмид/-д даалгасугай.

7. Төлөвлөгөөний биелэлтийг тухайн оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор тайлагнаж байхыг сумдын Засаг дарга, агентлаг, төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч, захирал нарт даалгасугай.

8. Захирамжийн хэрэгжилтэд жилд 1 удаа хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ-дотоод аудитын хэлтэс /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХНАСАН